

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 7561 дугаарт бүртгэв.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар А/42

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийн зохицуулах газар (Д.Батзориг)-т даалгасугай.

3.Журам шинэчлэн баталсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 159 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

*Эрчим хүчний сайдын 2026 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн А/42
дугаар тушаалын хавсралт*

ХЭРЭГЛЭГЧИЙН СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮҮСГҮҮРЭЭС ҮЙЛДВЭРЛЭСЭН ЭРЧИМ ХҮЧИЙГ ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД НИЙЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар иргэн, хуулийн этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох, хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Иргэд хамтран өөрсдийн дундын эзэмшлийн талбайд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр суурилуулах тохиолдолд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий этгээдийг тодорхойлон цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг тухайн этгээдээр дамжуулан байгуулж болно.

1.3.Сэргээгдэх эрчим хүчний 1,500 кВт-аас дээш суурилагдсан хүчин чадалтай үүсгүүрт энэ журам хамаарахгүй.

1.4.Хэрэглэгч нь тусгай зөвшөөрөлтэй угсралт, суурилуулалтын компани (цаашид “гүйцэтгэгч компани” гэх)-аар дамжуулан өөрийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг түгээх сүлжээнд холбоно.

1.5.“Суурилагдсан хүчин чадал” гэж үүсгүүрийн инвертерийн нэрлэсэн нийт хүчин чадлыг ойлгоно.

1.6.“Хялбаршуулсан хүсэлт” гэж энэ журмын 3.4 дэх заалтын дагуу сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг эзэмших хэрэглэгчээс Маягт №2-ын загвараар гаргах хүсэлтийг хэлнэ.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1.Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.1.1.Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс системийн үйлдвэрлэлт, түгээлтийн төлөвлөгөөнд хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн үйлдвэрлэлийг тусгаж ирүүлсэн саналыг хянах;

2.1.2.Түгээх сүлжээнд холбогдсон үүсгүүрийн мэдээллийг нэгтгэн олон нийтэд мэдээлэх;

2.1.3.Хэрэглэгчийн үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох дарааллыг тайлбарласан зөвлөмж, нэг маягийн зураг төсөл, цахим хуудсанд байршуулах;

2.1.4.Хэрэглэгчийн үүсгүүрт ашиглах тоног төхөөрөмж болон угсралт, суурилуулалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын жагсаалтыг өөрийн цахим хуудсанд байршуулж, тогтмол шинэчлэх;

2.1.5.Стандартуудын шаардлагуудыг боловсруулж, цахим хуудсанд байршуулах;

2.1.6.Нэг маягийн зураг төслийг боловсруулж, батлах.

2.2.Эрчим хүчний зохицуулах хороо нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.2.1.Системийн үйлдвэрлэлт, түгээлтийн төлөвлөгөөнд хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг үйлдвэрлэлийг тусган батлах;

2.2.2.Хэрэглэгчийн үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифыг тогтоож, батлах;

2.2.3.Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардалд түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг тусгах.

2.3.Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.3.1.Цахилгаан эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөнд хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн үйлдвэрлэлийг тусгаж саналаа Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх;

2.3.2.Жил бүр түгээх сүлжээнд холбогдох боломжтой үүсгүүрийн хүчин чадлын нарийвчилсан судалгааг гаргах;

2.3.3.Түгээх сүлжээнд холбогдсон үүсгүүрийн мэдээллийг Маягт №3-ын дагуу жил бүр гаргаж, Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад газруудад хүргүүлэх;

2.3.4.Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчний төлбөрийг хангагч, хэрэглэгч хооронд байгуулсан гэрээний дагуу сар бүр хэрэглэгчид олгох;

2.3.5.Энэ журмын 3.1-т заасан хэмжээг үндэслэл болгож тухайн хэрэглэгчийн үүсгүүрийн боломжит чадлыг тогтоож, хялбаршуулсан хүсэлт шийдвэрлэх эсвэл техникийн нөхцөл олгох;

2.3.6.Хялбаршуулсан хүсэлт болон техникийн нөхцөл олгох, техникийн нөхцөлийн дагуу холбох үйлчилгээ үзүүлэх төлбөрийг иргэн, хуулийн этгээдээс авах;

2.3.7.Хэрэглэгчтэй байгуулсан Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд энэ журмын хүрээнд нэмэлт оруулах;

2.3.8.Хэрэглэгчийн үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох дарааллыг тайлбарласан зөвлөмж, нэг маягийн зураг төсөл, өөрийн цахим хуудсанд байршуулах;

2.3.9.Энэ журмын шаардлага хангаагүй хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг болзошгүй осол, аваариас урьдчилан

сэргийлэх зорилгоор түгээх сүлжээнд холбохгүй байх;

2.3.10.Хяналт мэдээллийн системийг бий болгох боломжийг бүрдүүлэх.

2.4.Хэрэглэгч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.4.1.Энэ журмаар тогтоосон суурилагдсан хүчин чадлын хязгаарт багтаасан сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр суурилуулах;

2.4.2.Өөрийн хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх;

2.4.3.Энэ журамд заасан техникийн шаардлага хангасан үүсгүүр, инвертер, тоолуур болон бусад дагалдах төхөөрөмжийг худалдан авах, суурилуулах, түгээх сүлжээнд холбохтой холбогдон гарах бүх зардлыг бүрэн хариуцах;

2.4.4.Үүсгүүрээс холболтын цэг хүртэлх тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, ашиглалт, засвар үйлчилгээ, гэмтэл саатлыг арилгах зардлыг хариуцах бөгөөд эдгээртэй холбогдон үүсэх хариуцлагыг Эрчим хүчний тухай хуулийн 30.1.8-д заасны дагуу хүлээх;

2.4.5.Үүсгүүрийн ашиглалт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх;

2.4.6.Үүсгүүрийн түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлийн бус дэд станц, шугам сүлжээнд холбогдох тохиолдолд тус тоноглолын өмчлөгч этгээдээс зөвшөөрөл авах;

2.4.7.Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой тоног төхөөрөмжийн ашиглалтын шаардлага хангахгүй болсон тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэж, Базелийн конвенц, Хог хаягдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.5.Гүйцэтгэгч компани нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.5.1.Гүйцэтгэгч компани нь дараах тусгай зөвшөөрлүүдийн аль нэгийг эзэмшсэн байна. Үүнд:

2.5.1.1.ТЗ-1.1: 0.1-5 МВт-ын хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх болон түүнээс дээш;

2.5.1.2.ТЗ-2.1: 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх болон түүнээс дээш;

2.5.2.Энэ журмын 2.5.1.2-т заасан тусгай зөвшөөрөл нь 100 кВт болон түүнээс доош хүчин чадалтай үүсгүүрийг суурилуулах;

2.5.3.Түгээх сүлжээ талаас хүчдэлгүй болсон тохиолдолд үүсгүүрээс түгээх сүлжээ рүү хүчдэл өгөхгүй байх тоног төхөөрөмжийг суурилуулах;

2.5.4.Энэ журмын 2.5.3-т заасан шаардлагыг хангаагүйн улмаас учирсан хохирлыг бүрэн хариуцах;

2.5.5.Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй MNS 1778:2007 үндэсний стандартын шаардлагыг хангасан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2.5.6.Сүлжээнд холбох зорилгоор Маягт №1-ийн дагуу шалгах хуудсыг бөглөж, баталгаажуулах;

2.5.7.Үүсгүүрийн байршил, тухайн үеийн чадал, үйлдвэрлэсэн эрчим хүч зэрэг шаардлагатай мэдээллийг ТХТЗЭ-ээс тогтоосон протокол, хугацаа, цагийн интервалын дагуу дамжуулах боломжтой төхөөрөмжийг ашиглах.

Гурав.Үүсгүүрийн хүчин чадал, техникийн шаардлага

3.1.Хэрэглэгч нь дараах хүчин чадлын хязгаарын хүрээнд өөрийн эрчим хүчний хэрэглээний хязгаарт багтааж үүсгүүр суурилуулах боломжтой. Үүнд:

3.1.1.Ахуйн хэрэглэгч 20 кВт болон түүнээс доош хүчин чадалтай үүсгүүр суурилуулна;

3.1.2.Хуулийн этгээд, иргэд нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг техникийн нөхцөлөөр тогтоосон чадлын 50 хувиас ихгүй хүчин чадалтайгаар суурилуулна. Харин түгээх сүлжээний зангилааны нэвтрүүлэх чадлын тооцоо, хэрэглэгчийн бодит ачаалал, сүлжээнд буцах чадлын урсгал болон хүчдэлийн горимд үзүүлэх нөлөөллийн үнэлгээгээр уг хязгаарыг нэмэгдүүлэх эсхүл бууруулж тогтоож болно.

3.2. 20 кВт-аас дээш хүчин чадалтай үүсгүүр суурилуулах тохиолдолд 20%-ийн доошгүй чадалтай 2 цагийн доошгүй багтаамжтай батарей хуримтлууртай байна.

3.3.Зөвхөн өөрийн хэрэгцээг хангах зорилгоор түгээх сүлжээнд нийлүүлэхгүй тохиолдолд энэ журмын 3.1 дэх заалт хамаарахгүй.

3.4.Суурилагдсан хүчин чадал нь 20 кВт болон түүнээс доош үүсгүүрт техникийн нөхцөл шаардахгүй бөгөөд хэрэглэгч хялбаршуулсан хүсэлт гаргана. Суурилагдсан хүчин чадал нь 20 кВт-аас дээш тохиолдолд техникийн нөхцөл авна.

3.5.Бүх үүсгүүрийг түгээх сүлжээний 0.22-10 кВ-ын хүчдэлийн түвшинд холбохоор төлөвлөнө.

3.6.Цахилгаан эрчим хүчний чадлын урсгалыг хоёр чиглэлд хэмжиж, хэрэглээ болон түгээх сүлжээнд нийлүүлсэн эрчим хүчний төлбөр тооцоог хийх зориулалт бүхий, Стандарт хэмжил зүйн газраар баталгаажсан, тухайн түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлбөр тооцоонд ашиглагдаж буй ухаалаг тоолууртай байна. Хэрэглэгчийн хүсэлтээр нэг ухаалаг тоолуур эсхүл хоёр тусдаа тоолуур ашиглаж болно.

3.7.Үүсгүүр, түүний дагалдах тоног төхөөрөмж нь олон улсын стандартын шаардлага хангасан байна. Үүнд:

3.7.1.Нарны дэлгэц: IEC61730 Electrical safety & fire protection (Цахилгааны аюулгүй байдал, галын хамгаалалт) түүнтэй дүйцэхүйц;

3.7.2.Бага чадлын салхин турбин: IEC 61400-2 Small Wind Turbines (Жижиг салхин турбин);

3.7.3.Инвертер: IEEE1547: Grid interconnection (Сүлжээний харилцан холболт), IEC61727: PV system grid connection characteristics (PV системийн сүлжээний холболтын шинж чанар), IEC62116: Anti-islanding protection (Сүлжээнд холбогдсон нарны цахилгаан үүсгүүр(PV)-ийн инвертерүүдэд арлын эсрэг аргачлалыг шалгах туршилтын дарааллыг тодорхойлсон олон улсын стандарт) түүнтэй дүйцэхүйц;

3.7.4.Батарей: IEC 62619: Secondary cells and batteries containing alkaline or other non-acid electrolytes - Safety requirements for secondary lithium cells and batteries, for use in industrial applications (Аж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах, дахин цэнэглэгдэх Лити-Ион элемент болон баттарейг аюулгүй ашиглах шаардлага, туршилтыг тодорхойлсон олон улсын аюулгүй байдлын стандарт), UL 9540: Energy storage system safety (Эрчим хүч хадгалах системийн аюулгүй байдал) түүнтэй дүйцэхүйц.

3.8.Суурилагдсан хүчин чадал нь 20 кВт болон түүнээс доош үүсгүүрийг нэг маягийн зураг төслийн дагуу, 20 кВт-аас дээш хүчин чадалтай үүсгүүрийг батлагдсан ажлын зургийн дагуу тус тус гүйцэтгэнэ.

3.9.Үүсгүүр нь холбогдох норм, стандартын шаардлагад нийцсэн газардуулах байгууламжтай байна.

Дөрөв.Сүлжээнд холбох

4.1.Суурилагдсан хүчин чадал нь 20 кВт болон түүнээс доош тохиолдолд дараах дарааллын дагуу:

4.1.1.Хэрэглэгч эсхүл гүйцэтгэгч компани нь Маягт №2-ын дагуу хялбаршуулсан хүсэлтийг түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид гаргана. Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор судалж, холбох боломжийн талаар хариу мэдэгдэнэ;

4.1.2.Угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа гүйцэтгэгч компани Маягт №1-ийн дагуу шалгах хуудсыг бөглөж, баталгаажуулан сүлжээнд холбуулах хүсэлтийн хамт түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ;

4.1.3.Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор гүйцэтгэгч болон захиалагчийн хамт газар дээр нь шалгалт хийж, тоолуурт лац тавьж, сүлжээнд холбох эсэхийг шийдвэрлэнэ;

4.1.4.Сүлжээнд холбох шаардлага хангасан тохиолдолд

түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ажлын 3 хоногийн дотор цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд нэмэлт оруулна.

4.2.Суурилагдсан хүчин чадал нь 20 кВт-аас дээш тохиолдолд дараах дарааллын дагуу:

4.2.1.Хэрэглэгч нь техникийн нөхцөл авах хүсэлтийг түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид гаргана. Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүсэлтийг ажлын 10 хоногийн дотор судалж, техникийн нөхцөл олгох эсэх талаар хариу мэдэгдэнэ;

4.2.2.Олгосон техникийн нөхцөлийн дагуу ажлын зургийг холбогдох эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлнэ. Эрчим хүчний эрх бүхий байгууллага нь зураг төслийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор магадлал хийнэ (Зураг төсөл гүйцэтгэгч байгууллагыг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн тогтооно);

4.2.3.Угсралтын ажлыг батлагдсан ажлын зургийн дагуу гүйцэтгэсний дараа гүйцэтгэгч болон зураг төсөл гүйцэтгэгч байгууллага нь Маягт №1-ийн дагуу шалгах хуудсыг бөглөж, баталгаажуулан сүлжээнд холбуулах хүсэлтийн хамт ТХТЗЭ-д хүргүүлнэ;

4.2.4.Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор гүйцэтгэгч болон захиалагчийн хамт газар дээр нь шалгалт хийж, тоолуурт лац тавьж, сүлжээнд холбох эсэхийг шийдвэрлэнэ;

4.2.5.Сүлжээнд холбох шаардлага хангасан тохиолдолд Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ажлын 3 хоногийн дотор цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд нэмэлт оруулна.

Тав.Хяналт, хариуцлага

5.1.Энэ журмын биелэлтэд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, дүүрэг, сумын Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан, салбарын хяналт хэрэгжүүлэх байгууллага, нэгжийн улсын байцаагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч хяналт тавина.

5.2.Барилга угсралт, суурилуулалтын ажил гүйцэтгэгч компани нь Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3.Хэрэглэгч нь үүсгүүрээс холболтын цэг хүртэлх тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, ашиглалт, засвар үйлчилгээ, гэмтэл саатлыг арилгах зардлыг хариуцах бөгөөд эдгээртэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.

5.4.Энэ журмыг зөрчсөн гэм буруутай талуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

5.5.Захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран учруулсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлүүлнэ.

5.6.Эрчим хүчний тухай хуулийн 35.1-д зааснаас бусад тохиолдолд Зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь өөрийн эрх мэдэлд хамаарах асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

Маягт №1

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮҮСГҮҮРИЙГ ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ЗАЛГАХАД ШАЛГАХ ХУУДАС

Хэрэглэгчийн нэр: Хэрэглэгчийн код:

Үүсгүүрийн төрөл: ☐ НЦҮ (PV) ☐ НЦҮ (PV)+Батарей ☐ Салхи
☐ Хосолмол ☐ Бусад

Инвертерийн нийт хүчин чадал:..... /кВт/

Гүйцэтгэгч компани:

Техникийн нөхцөлийн дугаар*: Зургийн дугаар**:

Хаяг, байршил:

Нарны дэлгэц:

Үйлдвэрлэгч		Марк	
Нэгж чадал	Вт	Тоо ширхэг	ш
Хамгийн их хүчдэл	В	Хамгийн их гүйдэл	А
Цуваа холболтын тоо		Зэрэгцээ холболтын тоо	
Олон улсын стандарт			

Салхин цахилгаан үүсгүүр:

Үйлдвэрлэгч		Марк	
Хүчдэлийн түвшин	В	Хамгийн их гүйдэл	А
Нэгж чадал	Вт	Тоо ширхэг	ш
Олон улсын стандарт			

Инвертер:

Үйлдвэрлэгч		Марк	
Нэгж чадал	кВт	Тоо ширхэг	ш
Хүчдэлийн түвшин (хувьсах)	В	Хамгийн их гүйдэл (тогтмол)	А
MPPT хүчдэл	В	MPPT тоо	
Олон улсын стандарт			

Батарей:

Үйлдвэрлэгч		Марк	
Чадал	кВт	Багаамж	кВт*ц
Хамгийн их хүчдэл	В	Хамгийн их гүйдэл	А
Цуваа холболтын тоо		Зэрэгцээ холболтын тоо	

Олон улсын стандарт	
---------------------	----------------

Газардуулга:

Газардуулгын эсэргүүцэл	Ом	Хэмжилт хийсэн огноо	
Хэмжилт хийсэн байгууллагын нэр		Ажилтны нэр:	
Хэмжилтийн багажны марк			

Хавсаргасан баримт бичгийн жагсаалт:

1.....

2.....

.....ГЭХ МЭТ

Чанарын баталгаат хугацаа: жил

Баталгаажуулалт:

Зургийн компани	Байгууллагын нэр:	Инженерийн нэр	Гарын үсэг
Угсралтын компани:	Компанийн нэр:	Инженерийн нэр	Гарын үсэг

ХУВЬСАХ (АС) ТАЛЫН СҮЛЖЭЭ ХОЛБОЛТ

Шалгах зүйл	Тийм	Үгүй	Тайлбар
АС таслуур	☐	☐	
Anti-islanding идэвхтэй	☐	☐	

ДҮГНЭЛТ

- ☐ Ашиглалтад оруулах БОЛОМЖТОЙ
- ☐ Засварлах шаардлагатай

Захиалагч	Иргэн, хуулийн этгээд		Гарын үсэг
Хангах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч	Байгууллагын нэр:	Инженерийн нэр	Гарын үсэг

Санамж: * 20 кВт болон түүнээс доош сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр техникийн нөхцөл авах шаардлагагүй.

** 20 кВт болон түүнээс доош сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр нэг маягийн ажлын зургаар гүйцэтгэнэ.

Маягт №2

ХЯЛБАРШУУЛСАН ХҮСЭЛТ*

Хэрэглэгчийн нэр: Хэрэглэгчийн код:

Үүсгүүрийн төрөл: ☐ НЦҮ (PV) ☐ НЦҮ (PV)+Батарей ☐ Салхи
☐ Хосолмол ☐ Бусад

Хаяг, байршил:

Үүсгүүрийн чадал:.....кВт Батарей багтаамж: кВтц

Хүсэлт гаргасан: Хэрэглэгч эсвэл гүйцэтгэгч компани

ШИЙДВЭРЛЭЛТ (ТХТЗЭ)

- ☐ Зөвшөөрсөн
- ☐ Хүчин чадлыг багасгаж..... кВт. (шалтгаан:.....)
- ☐ Татгалзах (шалтгаан:

*Санамж: * Зөвхөн 20 кВт болон түүнээс доош сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг холбоход ашиглана.*

Хэрэглэгчийн код	СЭХ-ний үүсгүүрийн төрөл	Хүчин чадал (кВт)	Батарей багтаамж (кВт*ц)	Холбогдсон огноо	Гэрээ байгуулсан огноо	Нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний хэмжээ (кВт*ц)	Төлбөр тооцоо (төгрөг)

ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 7/16

Баян-Овоо сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАР ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын малчин болон мал бүхий этгээдийн өмчилж буй нэг малын тоо толгойд төлөх албан татварын хувь хэмжээг тэмээ-1000, адуу-1000, үхэр-1000, хонь-500, ямаа-500 төгрөгөөр тогтоосугай.

2.Сумын жилийн эцсийн мал тооллогын дүн, статистикийн баримтыг үндэслэн дээрх хэмжээгээр жил бүр татварын орлогыг бүрдүүлэхийг зөвшөөрсүгэй.

3.Малын тоо толгойн албан татварыг иргэдэд сурталчлан таниулж, ноогдуулсан албан татварыг төсөвт төвлөрүүлж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг сумын Засаг дарга (О.Оргилсайхан)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 07 -ны өдрийн 5/3 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.СОНИНБАЯР

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 2 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах журам”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам батлах тухай” 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 29 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн
24 тоот тогтоолын хавсралт*

**МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ
БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж (цаашид “тоног төхөөрөмж гэх”)-д баталгаажуулалт, тохирлын үнэлгээ хийх нь дараах зорилготой:

1.1.1.Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал, радио давтамжийн холбогдох стандарт, норматив техникийн баримт бичиг, тогтоосон шаардлага хангасныг нотлох;

1.1.2.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтын хэрэгжилтийг хангах;

1.1.3.Тоног төхөөрөмжийг баталгаажуулах, баталгаажсан тоног төхөөрөмжид тохирлын гэрчилгээ олгох, хүчингүй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах;

1.1.4.Зах зээлд хуурамч болон стандарт шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүн орж ирэхээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхолыг хамгаалах;

1.2.Энэхүү журмын хэрэгжилтэд 3 жил тутамд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж сайжруулна.

Хоёр. Хамрах хүрээ

2.1.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд (цаашид “Хүсэлт гаргагч” гэх) нь эрх бүхий байгууллагаас баталсан тохирлын баталгаанд хамруулах бүтээгдэхүүний жагсаалтад орсон тоног төхөөрөмжийг заавал баталгаажуулна.

2.2.Энэ журмын 2.1-д зааснаас бусад тоног төхөөрөмжийг сайн дурын үндсэн дээр баталгаажуулна.

Гурав. Баталгаажуулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим

3.1.Баталгаажуулалтын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална.

3.1.1.баримт, нотолгоонд үндэслэсэн байх;

3.1.2.ялгаварлахгүй байх;

3.1.3.шударга байх;

3.1.4.шуурхай, тасралтгүй байх;

3.1.5.нээлттэй, ил тод байх;

Дөрөв. Ерөнхий нөхцөл

4.1. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д тус тус заасны дагуу мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг зах зээлд нийлүүлэх болон нэвтрэх, үйлдвэрлэсэн тоног төхөөрөмжийг тогтоосон шаардлагад нийцсэнийг баталгаажуулж, тохирлын гэрчилгээ олгоно.

4.2. Баталгаажуулалтыг хэрэглээгээр нь 3 ангилна. Үүнд:

4.2.1. Импортын баталгаажуулалт;

4.2.2. Дотоодын үйлдвэрлэлийн баталгаажуулалт;

4.2.3. Экспортын баталгаажуулалт;

4.3. Тоног төхөөрөмжид нэмэлтээр суурилуулж, түүнд нэгдэн ажиллах боломжтой, эд ангийг дангаар нь баталгаажуулж болно.

4.4. Нэг ижил төрлийн төхөөрөмжүүд буюу загварын дугаарууд нь өөр боловч лабораторийн сорилт туршилт, үйлдвэрлэгчийн мэдэгдэл нь ижил тохиолдолд багц тоног төхөөрөмж гэж үзнэ.

Тав. Хүсэлт гаргах

5.1. Хүсэлт гаргагч нь тоног төхөөрөмжийг баталгаажуулах хүсэлтийг Зохицуулах хорооноос баталсан маягтын дагуу цаасаар эсвэл цахимаар гаргана.

5.2. Хүсэлт нь монгол хэл дээр байх ба шаардлагатай тохиолдолд хавсаргах баримт бичгийг англи хэл дээр ирүүлж болно.

5.3. Баталгаажуулалт хийлгэх хүсэлтэд дараах баримт бичгүүдийг хавсаргана.

5.3.1. хүсэлт гаргасан үндэслэлийг тодорхойлсон албан бичиг, үйл ажиллагааны танилцуулга, төлөвлөгөө;

5.3.2. хүсэлт гаргагч болон үйлдвэрлэгч эсхүл нийлүүлэгчийн хамтын ажиллагааг баталгаажуулсан баримт;

5.3.3. үйлдвэрлэгч эсхүл нийлүүлэгчийн мэдэгдэл;

5.3.4. баталгаажуулах тоног төхөөрөмжийн мэдээлэл (танилцуулга, хэрэглэгчийн гарын авлага, ашиглалтын заавар, тоног төхөөрөмжийн гадна болон дотоод бүтцийн зураг, блок схем гэх мэт);

5.3.5. холбогдох стандарт, бусад норматив баримт бичгийг хангасан хүчин төгөлдөр хугацаатай сорилт туршилтын дүн;

5.3.6. тохирлын гэрээ болон гэрчилгээний загвар;

5.4. Энэхүү журмын 5.3.5-д заасан сорилт туршилтын дүнд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (Health & Safety), цахилгаан соронзон зохицоо (Electromagnetic compatibility), радио давтамж (Radio frequency)-ийн мэдээллийг тусгасан байна.

5.5.Лабораторийн сорилт туршилтын дүн нь олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд энэхүү журмын 5.4-т заасан нөхцлийг хангасан гэж үзнэ.

5.6.Зохицуулах хороо нь тоног төхөөрөмжийг баталгаажуулж, тохирлын үнэлгээ хийхэд шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагчаас тоног төхөөрөмжийн дээжийг авч сорилт туршилт хийж болно.

5.7.Энэхүү журмын 5.3-т заасан баримт бичиг бүрдээгүй тохиолдолд бүрдлийг хангуулахаар хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. Хүсэлт гаргагч нь хүсэлтийг шийдвэрлэх хугацааны дотор шаардлагатай бүрдлийг гаргаж өгөөгүй тохиолдолд тохирлын үнэлгээ хийгдэхгүй.

5.8.Энэхүү журмын 5.3-д заасан бүрдэл хангагдаагүй бол хүсэлт гаргагчид цахимаар мэдэгдэх ба баримт бичгийг буцаан хүргүүлнэ.

Зургаа. Тохирлын үнэлгээ хийх, шийдвэр гаргах

6.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх авсан мэргэшсэн шинжээчийн эрхтэй Зохицуулах хорооны ажилтан нь тохирлын үнэлгээг хийнэ.

6.2.Өмнө нь туршилтад орж байгаагүй шинэ, дэвшилтэд технологиор үйлдвэрлэсэн, үйлдвэрлэлийн явц, газар дээрх үнэлгээ, тоног төхөөрөмжийн дээжид сорилт туршилт хийх шаардлагатай тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсэгт мэргэжлийн, мэргэшсэн этгээдийг татан оролцуулна.

6.3.Мэргэшсэн шинжээч, ажлын хэсэг нь баталгаажуулалтын үйл ажиллагааны явцад олж авсан иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэлийн болон технологийн мэдээллийн нууцыг хадгалж, зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

6.4.Мэргэшсэн шинжээч, ажлын хэсэг нь ирүүлсэн баримт бичгийг үнэлэхдээ “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах схем”-ээс тохирохыг сонгож, дүн шинжилгээ хийнэ.

6.5.Баталгаажуулахаар хүсэлт гаргасан тоног төхөөрөмжид хийгдсэн сорилтын дүн нь Монгол Улсын болон Олон улсын стандартыг хангах бөгөөд ажиллах радио давтамж нь Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт, Зохицуулах хорооноос баталсан радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага, бусад холбогдох норматив техникийн баримт бичгийг хангасан байна.

6.6.Шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагчийн баталгаажуулах тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн явцад газар дээрх үнэлгээг хийж болно.

6.7.Мэргэшсэн шинжээч, ажлын хэсэг нь тохирлын үнэлгээний дүгнэлт гаргана.

6.8.Үнэлгээний явцад оролцоогүй ажилтан тохирлын үнэлгээний

дүгнэлтэд дүн шинжилгээ хийж, баталгаажуулна.

6.9.Зохицуулах хороо нь хүсэлт гаргагчаас ирүүлсэн хүсэлтийг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор тохирлын гэрчилгээ олгох шийдвэр гаргах ба шийдвэр нь Зохицуулах хорооны даргын тушаал байна.

6.10.Тохирлын гэрчилгээ олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

6.11.Тохирлын гэрчилгээг энэхүү журмын Хавсралт 1 “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах схем”-д заасан хугацаагаар олгоно.

6.12.Тохирлын гэрчилгээг хүсэлт гаргагчийн хүсэлтэд үндэслэн монгол эсвэл англи хэл дээр гаргаж өгнө.

6.13.Тохирлын гэрчилгээнд дараах мэдээллийг тусгана:

6.13.1.Хүсэлт гаргагчийн нэр, хаяг;

6.13.2.Үйлдвэрлэгчийн нэр, хаяг;

6.13.3.Тоног төхөөрөмжийн нэр, загвар, түүнтэй холбоотой мэдээлэл;

6.13.4.Үйлдвэрлэгч улс;

6.13.5.Тоног төхөөрөмжийн ажиллах радио давтамж, технологи, хангах стандарт;

6.13.6.Сорилт туршилт хийсэн лаборатори болон тайлангийн мэдээлэл;

6.13.7.Тохирлын үнэлгээний шийдвэр, шаардлагатай бол анх тохирлын гэрчилгээ авсан огноо;

6.13.8.Тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа;

6.13.9.Баталгаажуулалтын байгууллагын нэр, хаяг;

6.14.Хүсэлт гаргагчийн хүсэлтийн дагуу төлөвлөгөө болон үйлдвэрлэгч эсхүл нийлүүлэгчийн итгэмжлэлийг үндэслэн энэхүү журмын 6.13.1-д заасан мэдээлэлд үйлдвэрлэгч эсхүл нийлүүлэгчийн нэрийг бичиж болно.

6.15.Хэрэв хүсэлт гаргагч нь тохирлын гэрчилгээнд давтан тохирлын үнэлгээ хийлгэх бол хүчинтэй тохирлын гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Зохицуулах хороонд хүсэлтийг ирүүлнэ.

6.16.Тохирлын гэрчилгээний бичилт болон түүнтэй адилтгаж болох өөр бусад илэрхий алдааг тохирлын гэрчилгээний үндсэн агуулгыг өөрчлөхгүйгээр Зохицуулах хороо эсхүл тохирлын гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр тохирлын гэрчилгээг засаж болно.

Долоо. Шийдвэрийг мэдэгдэх, гэрээ байгуулах

7.1.Зохицуулах хороо нь хүсэлт гаргагчийн бүртгүүлсэн цахим хаягт тохирлын гэрчилгээ олгож шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг

хүргүүлнэ.

7.2.Хүсэлт гаргагч нь энэхүү журмын 7.1-д заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор гэрээ байгуулж, тохирлын гэрчилгээг хүлээж авна.

7.3.Энэхүү журмын 7.2-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гаргасан шийдвэрийг цуцлах үндэслэл болно.

Найм. Магадлан хяналт

8.1.Зохицуулах хороо нь тохирлын гэрчилгээ авсан тоног төхөөрөмжүүдэд тохирлын үнэлгээний шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгаа эсэхийг магадлан хяналт хийх замаар нотолж, баримтжуулна.

8.2.Зохицуулах хороо нь дараах аргуудыг цогцоор нь эсхүл аль нэгээр нь магадлан хяналтыг хийнэ:

8.2.1.бүртгэлд суурилсан¹;

8.2.2.эрсдэлд суурилсан²;

8.2.3.бодит байдалд суурилсан³;

8.3.Зохицуулах хороо нь “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах схем”-д магадлан хяналт хийхээр заагдсан тохирлын гэрчилгээ эзэмшигчдэд тохирлын гэрчилгээ авснаас хойш нэг жилийн дараагаас эхлэн жил бүр магадлан хяналт хийнэ.

8.4.Эрсдэлд суурилсан магадлан хяналтыг энэхүү журмын 8.3-д заасан хугацааг харгалзахгүйгээр тохирлын гэрчилгээний хүрээнд магадлан хяналт хийж болно.

8.5.Магадлан хяналтыг явуулахаас өмнө тохирлын гэрчилгээ эзэмшигчид урьдчилан мэдэгдэнэ.

8.6.Магадлан хяналтын үр дүнд үл тохирол илэрсэн тохиолдолд залруулах 30 хоногоос доошгүй хугацаа өгөх ба тухайн хугацаанд үл тохирлыг арилгаагүй бол тохирлын гэрчилгээг хүчингүй болгоно.

8.7.Тохирлын гэрчилгээ хүчингүй болсон тухай шийдвэрийг тохирлын гэрчилгээ эзэмшигч болон Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

¹ Бүртгэлд суурилсан магадлан хяналт гэдэг нь тоног төхөөрөмж баталгаажуулсан бүртгэлийн мэдээлэл, тайлан, мэдүүлэгт үндэслэн хууль тогтоомж, журам, стандартын шаардлагын хэрэгжилтийг үнэлэх үйл ажиллагааг хэлнэ.

² Эрсдэлд суурилсан магадлан хяналт гэдэг нь эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн тоног төхөөрөмжийн радио давтамж, техникийн үзүүлэлт, ажиллагааны онцлогоос хамаарч хүний аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх ашиг, зах зээл болон хүрээлэн буй орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх магадлан хяналтын үйл ажиллагааг хэлнэ.

³ Бодит байдалд суурилсан магадлан хяналт гэдэг нь тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйлдвэрлэлийн үйл явц, бүртгэлийн мэдээлэл хангалтгүй тохиолдолд газар дээр нь очиж магадлан хянах, хэмжилт, сорилт туршилт, нотлох баримт цуглуулах замаар хууль тогтоомж, журам, стандартын шаардлагын хэрэгжилтийг үнэлэх үйл ажиллагааг хэлнэ.

8.8.Зохицуулах хороо нь эрсдэлд суурилсан магадлан хяналтыг хийх тохиолдолд тоног төхөөрөмжийг зах зээлээс түүвэрлэн авч итгэмжлэгдсэн лабораторид сорилт туршилтыг хийж, үр дүнг хэрэглэгчдэд мэдэгдэнэ.

Ес. Тохирлын гэрчилгээг хүчингүй болгох

9.1.Тохирлын гэрчилгээ эзэмшигчийн хүсэлт эсхүл магадлан хяналтын дүнг үндэслэн тохирлын гэрчилгээг хүчингүй болгоно.

9.2.Тохирлын гэрчилгээ эзэмшигчээс давтан үнэлгээ хийлгэх хүсэлт ирүүлээгүй бөгөөд тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд тоног төхөөрөмжийн баталгаажуулалтыг дуусгавар болсонд тооцно.

Арав. Бусад

10.1.Зохицуулах хороо нь тохирлын тэмдэгийг оюуны өмчийн эрхтэйгээр бүртгүүлж ашиглах ба сайн дурын баталгаажуулалт дээр тохирлын тэмдэгийг хэрэглэж болно.

10.2.Зохицуулах хороо нь баталгаажуулалтын шийдвэр болон хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээ эзэмшигчдийн мэдээллийг цахим хуудаст ажлын 5 хоногийн дотор байршуулж, нээлттэй мэдээлнэ.

10.3.Гомдол, маргаан гарсан тохиолдолд холбогдох хууль, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

*“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг
баталгаажуулах журам”-ын
Нэгдүгээр хавсралт*

**МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ
БАТАЛГААЖУУЛАХ СХЕМ**

№	Схемийн дугаар	Схем 1а	Схем 4	Схем 6	Схем 7
Схемийн хэрэглээ		Импорт (дээжтэй)	Дотоод	Экспорт	Импорт (дээжгүй)
Үйл явц					
Тохирлын гэрчилгээний хугацаа		4 жил	4 жил	3 жил	3 жил
1	Хүсэлт болон холбогдох баримт бичгийг хүлээн авах, иж бүрдэл шалгах	√	√	√	√
2	Мэргэшсэн шинжээч, ажлын хэсэг томилох	√	√	√	√
3	Хүсэлтэд дүн шинжилгээ хийх	√	√	√	√
4	Газар дээрх үнэлгээг хийх	-	√	√	-
5	Тоног төхөөрөмжийн дээжид радио давтамжийн сорилт туршилт хийх	√	√	√	-
6	Дүгнэлт гаргах	√	√	√	√
7	Дүгнэлтэд хяналт тавих	√	√	√	√
8	Дүн шинжилгээ хийх	√	√	√	√
9	Шийдвэр гаргах, албажуулах	√	√	√	√
10	Шийдвэрийг мэдэгдэх	√	√	√	√
11	Тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулах	√	√	√	√
12	Тохирлын гэрчилгээ, гэрээ олгох	√	√	√	√
13	Баталгаажуулалтын тэмдэг хэрэглэхийг зөвшөөрөх	√	√	√	√
14	Магадлан хяналт хийх	√	√	√	√

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ СХЕМИЙГ АШИГЛАХ ТАЙЛБАР

№	Тайлбар
Схем 1а	Импортын тоног төхөөрөмж, заавал эсхүл сайн дурын баталгаажуулалт хийлгэх хүсэлтэй, дээж ирүүлсэн тоног төхөөрөмжид тохирлын үнэлгээ хийхэд энэхүү 1 дүгээр схем хамаарна: • Хүсэлтийн иж бүрдлийг шалгаж, баримт бичиг бүрэн тохиолдолд холбогдох стандарт, норм нормативийн шаардлага хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ. • Тоног төхөөрөмжийн дээжийг авч радио давтамжийн хэмжилт хийнэ. • Энэхүү журмын 5.3-5.6 дахь заалтууд бүрэн хангагдсан нотолгоонд үндэслэн дүгнэлт гаргана. • Дүгнэлтэд хяналт тавьж, баталгаажуулж шийдвэр гаргана. • Шийдвэрийг мэдэгдэж, тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулж, тохирлын гэрчилгээг олгоно. • Тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа 4 жил байна. • Тохирлын гэрчилгээ олгосноос хойш 1 жилийн дараагаас магадлан хяналт хийнэ.
Схем 4	Дотоодын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, заавал эсхүл сайн дурын баталгаажуулалт хийлгэх хүсэлтэй, дээж ирүүлсэн тоног төхөөрөмжид тохирлын үнэлгээ хийхэд энэхүү 4 дүгээр схем хамаарна: • Хүсэлтийн иж бүрдлийг шалгаж, баримт бичиг бүрэн тохиолдолд холбогдох стандарт, норм нормативийн шаардлага хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ. • Тоног төхөөрөмжийн дээжийг авч радио давтамжийн хэмжилт хийнэ. • Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж буй үйлдвэрлэлийн явцад газар дээрх үнэлгээг хийнэ. • Энэхүү журмын 5.3-5.6 дахь заалтууд бүрэн хангагдсан нотолгоонд үндэслэн дүгнэлт гаргана. • Дүгнэлтэд хяналт тавьж, баталгаажуулж шийдвэр гаргана. • Шийдвэрийг мэдэгдэж, тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулж, тохирлын гэрчилгээг олгоно. • Тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа 4 жил байна. • Тохирлын гэрчилгээ олгосноос хойш 1 жилийн дараагаас магадлан хяналт хийнэ.

Схем 6	Экпортод гаргах зорилготой дотоодын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, заавал эсхүл сайн дурын баталгаажуулалт хийлгэх хүсэлтэй, дээж ирүүлсэн тоног төхөөрөмжид тохирлын үнэлгээ хийхэд энэхүү 6 дугаар схем хамаарна: • Хүсэлтийн иж бүрдлийг шалгаж, баримт бичиг бүрэн тохиолдолд холбогдох стандарт, норм нормативийн шаардлага хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ. • Тоног төхөөрөмжийн дээжийг авч радио давтамжийн хэмжилт хийнэ. • Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж буй үйлдвэрлэлийн явцад газар дээрх үнэлгээг хийнэ. • Энэхүү журмын 5.3-5.6 дахь заалтууд бүрэн хангагдсан нотолгоонд үндэслэн дүгнэлт гаргана. • Дүгнэлтэд хяналт тавьж, баталгаажуулж шийдвэр гаргана. • Шийдвэрийг мэдэгдэж, тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулж, тохирлын гэрчилгээг олгоно. • Тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 жил байна. • Тохирлын гэрчилгээ олгосноос хойш 1 жилийн дараагаас магадлан хяналт хийнэ.
Схем 7	Импортын тоног төхөөрөмж, заавал эсхүл сайн дурын баталгаажуулалт хийлгэх хүсэлтэй, дээж ирүүлэх боломжгүй тоног төхөөрөмжид тохирлын үнэлгээ хийхэд энэхүү 7 дугаар схем хамаарна: • Хүсэлтийн иж бүрдлийг шалгаж, баримт бичиг бүрэн тохиолдолд холбогдох стандарт, норм нормативийн шаардлага хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ. • Энэхүү журмын 5.3-5.5 дахь заалтууд бүрэн хангагдсан нотолгоонд үндэслэн дүгнэлт гаргана. • Дүгнэлтэд хяналт тавьж, баталгаажуулж шийдвэр гаргана. • Шийдвэрийг мэдэгдэж, тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулж, тохирлын гэрчилгээг олгоно. • Тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 жил байна. • Тохирлын гэрчилгээ олгосноос хойш 1 жилийн дараагаас магадлан хяналт хийнэ.

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 2 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар А/41

Улаанбаатар
хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” /цаашид “Журам” гэх/-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.1. Журмын дараах зүйл, заалтыг дор дурдсанаар нэмсүгэй:

1/21.12 дугаар зүйл:

“21.12. Монгол Улсын Засгийн газраас олон улсын гэрээний хүрээнд гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн дүнг хөрөнгийн өртөгт оруулахгүй.

(а) Төслийн нэгж нь хөрөнгийг худалдан авсан дүнгээр бүртгэнэ:

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/

Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг

(б) Төслийн нэгж нь өмнөх тайлант үед татварын чөлөөлөлтийн дүнг орлогоор бүртгэж, хөрөнгийн өртөгт хуримтлуулан бүртгэсэн бол буцаах бичилт хийж залруулна:

Дт Хуримтлагдсан ашиг/алдагдал

Кт Хөрөнгө /нэр төрлөөр/

(в) Төслийн нэгж нь татварын чөлөөлөлт эдлээгүй тохиолдолд энэ журмын хавсралтын 10.10 дах хэсэгт заасны дагуу бүртгэнэ.

Татварын чөлөөлөлтийн дүнг санхүүгийн тайлангийн “Тодруулга 14. Татварын чөлөөлөлт”-д тодруулна.”

2/21.4 дүгээр зүйлийн (в) дэх заалт:

(в) Төслийн нэгж нь дээрх хөрөнгийг захиалагч талд шилжүүлэх үед:

Дт Хуримтлагдсан ашиг/алдагдал

Кт Бусад байгууллагад шилжүүлэх зорилгоор бэлтгэсэн үл хөдлөх хөрөнгө”

1.2.Журмын дараах зүйл, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10.42 дугаар зүйлийн (б) дэх заалт:

“10.42. (б) үндсэн хөрөнгө тусламжаар хүлээн авах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кт Бусад урьдчилж олсон орлого

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/өглөг

Бусад урьдчилж олсон орлогыг хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид системтэйгээр орлогоор хүлээн зөвшөөрнө.

Дт Бусад урьдчилж олсон орлого

Кт Хандив тусламж /гадаад/”

2/21.4 дүгээр зүйл:

“21.4.Гадаадын зээл болон тусламжаар санхүүжиж буй барилга, байгууламж, их засварын ажлын зардлыг ажил бүрэн дуусаж, ашиглалтад орох хүртэлх хугацаанд дуусаагүй барилга дансанд бүртгэж, санхүүгийн тайлангийн эргэлтийн бус хөрөнгө гэсэн ангилалд толилуулна.

(а) төслийн нэгж нь барилга, байгууламж болон их засварын ажлыг бүртгэх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кт Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого/

Хандив тусламж /гадаад/

Дт Дуусаагүй барилга, байгууламж

Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(б) Төслийн нэгж нь барилга байгууламж болон их засварын ажил бүрэн дуусаж, гүйцэтгэгч байгууллагаас хөрөнгийг хүлээн авсан үед:

Дт Бусад байгууллагад шилжүүлэх зорилгоор бэлтгэсэн үл

хөдлөх хөрөнгө

Кт Дуусаагүй барилга, байгууламж”

1.3.Журмын 10.53 дахь хэсэг, 21.2 дахь хэсгийн (б) дэх заалт, 10.42 дахь хэсгийн (в), (г) дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Мөн журмын хоёрдугаар хавсралтад дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

2.1.Хоёрдугаар хавсралтын “Санхүүгийн тайлангийн маягт” хэсэгт “Тодруулга 14. Татварын чөлөөлөлт” гэсэн тодруулгыг хавсралтад зааснаар нэмсүгэй.

2.2.Хоёрдугаар хавсралтын “Санхүүгийн үр дүнгийн тайлангийн СТ-2 маягт”-ын “Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал”

гэснийг “Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал” гэж, Мөнгөн гүйлгээний тайлангийн СТ-3 маягтын “Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал” гэснийг “Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал” гэж, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн “Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал” гэснийг “Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал” гэж, Санхүүгийн тайлангийн тодруулгын Тодруулга 3.Зардлын хэсгийн 7-д “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэснийг “Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Мөн журмын гуравдугаар хавсралтад дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

3.1.Гуравдугаар хавсралтын 2.2. дахь хэсгийн “Зардлын эдийн засгийн ангилал”-ын харгалзах хүснэгтэд дараах хүснэгт нэмсүгэй:

210305 “Хөрөнгийн ашиглалт менежмент”;

210810 “Тохижилт үйлчилгээ”;

210811 “Судалгаа, хөгжүүлэлт”;

210812 “Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ”;

210903 “Мэдээлэл, сурталчилгааны зардал”;

222002 “ТЭЗҮ, зураг төсөв”;

222003 “Цахим систем”

3.2.Гуравдугаар хавсралтын 2.1. дэх хэсгийн “Орлогын эдийн засгийн ангилал” гэснийг “Орлогын данс” гэж, тус орлогын дансны 113002 “Бууны албан татвар” гэснийг 113002 “Галт зэвсгийн албан татвар” гэж, 113004 “Малд ногдуулах албан татвар” гэснийг 113004 “Малын тоо толгойн албан татвар” гэж, 2.2 дахь хэсгийн “Зардлын эдийн засгийн ангилал” гэснийг “Зардлын данс” гэж, тус зардлын дансны 2108 “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэснийг 2108 “Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэж, 210801 “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэснийг 210801 “Мэргэжлийн үйлчилгээний төлбөр” гэж, 210804 “Тээврийн хэрэгслийн татвар” 210805 “Тээврийн хэрэгслийн оношилгоо” гэснийг 210804 “Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо” гэж, 210807 “Газрын төлбөр” гэснийг 210807 “Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж” гэж, 210902 “Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” гэснийг 210902 “Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал” гэж, 2.3 “Балансын дансны жагсаалт” гэснийг 2.3 “Санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалт” гэж тус тус өөрчилсүгэй.

3.3.Гуравдугаар хавсралтын 2.1. Орлогын эдийн засгийн ангиллын “1102 Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ, хувиараа эрхлэгч” гэснийг, “1104 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар” гэснийг, 2.2. Зардлын эдийн засгийн ангиллын “210808 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж” гэснийг тус тус хассугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/, Төрийн сангийн газар /Б.Цогбадрах/- т тус тус үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

Сангийн сайдын 2026 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн
А/41 дүгээр тушаалын хавсралт

ТОДРУУЛГА 14. ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

№	Татварын төрөл	Тайлант хугацааны татварын чөлөөлөлтийн дүн	Нийт чөлөөлөлтийн дүн
1	Импортын гаалийн албан татвар		
2	Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ		
3	Импортын барааны НӨАТ		
	Нийт дүн		

Тэмдэглэл: (Монгол Улсын Засгийн газраас олон улсын гэрээний хүрээнд тухайн тайлант хугацаанд төслийн нэгжүүдэд үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн дүнг “Тайлант хугацааны чөлөөлөлтийн дүн” хэсэгт тусгана. “Нийт чөлөөлөлтийн дүн” хэсэгт тухайн төсөл хэрэгжиж эхэлснээс хойш тайлант хугацаанд ЗГ-аас үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн нийт дүнг тусгана.)

.....
.....
.....

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 2 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ БУУРУУЛЖ, ТҮР ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.1 дэх хэсэгт заасан брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн “0.04 хувьтай тэнцүү” гэснийг “0.02 хувьтай тэнцүү” гэж, хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогын “10.0 хувьтай тэнцүү” гэснийг “0 хувьтай тэнцүү” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.2 дахь хэсэгт заасан дилерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн “0.04 хувьтай тэнцүү” гэснийг “0.02 хувьтай тэнцүү” гэж, хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогын “10.0 хувьтай тэнцүү” гэснийг “0 хувьтай тэнцүү” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.7 дахь хэсэгт заасан үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдүүдийн авсан шимтгэлийн орлогын “10.0 хувьтай тэнцүү” гэснийг “5.0 хувьтай тэнцүү” гэж өөрчилсүгэй.

4. Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.1 дэх хэсгийн хувьцааны арилжааны хэлцэл тус бүрээс тооцох зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд түр чөлөөлсүгэй.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 2 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/24

Улаанбаатар
хот

ЗАРИМ БАРААНЫ ҮНДЭСНИЙ КОД, ХЭМЖИХ НЭГЖИД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 268¹ дүгээр зүйлийн 268¹.1.8, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын “Экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 51 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хурлын 01/01, 01/02 тоот шийдвэрийг үндэслэн Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/145 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт”-ын зарим үндэсний кодод оруулах нэмэлт, өөрчлөлтийг 1 дүгээр, зарим барааны хэмжих нэгжид оруулах нэмэлт, өөрчлөлтийг 2 дугаар, үндэсний кодын харьцуулсан хүснэгтийг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2.Үндэсний код, хэмжих нэгжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гаалийн бүрдүүлэлт, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын холбогдох газар, хэлтэс, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хорооны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайванд даалгасугай.

ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Гаалийн ерөнхий газрын даргын
2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
А/24 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

**БАРААГ ТОДОРХОЙЛОХ, КОДЛОХ УЯЛДУУЛСАН СИСТЕМД
ҮНДЭСЛЭСЭН ГАДААД ХУДАЛДААНЫ БАРААНЫ АНГИЛЛЫН
ЖАГСААЛТЫН ЗАРИМ ҮНДЭСНИЙ КОДОД ОРУУЛАХ НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ**

Д/д	Мөр	Үнд. код	Барааны бичиглэл	Хэмжих нэгж
1.	Мөр 0406.10-т дараах үндэсний код, бичиглэлийг нэмэх:			
1.1	0406.10		- Шинэ (бүрэн боловсроогүй эсвэл хатаагаагүй) бяслаг, түүнчлэн шар сүүнээс гаргасан бяслаг болон аарц:	
1.2	0406.10	30	--- Ааруул	кг
2.	Мөр 1515.90-д дараах үндэсний код, бичиглэлийг нэмэх:			
2.1	1515.90		- Бусад:	
2.2	1515.90	10	--- Чацарганы тос	кг
2.3	1515.90	20	--- Сибирь хуш (<i>Pinus Sibirica</i>)-ны самрын тос	кг
2.4	1515.90	90	--- Бусад	кг

Гаалийн ерөнхий газрын даргын
2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
А/24 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

**БАРААГ ТОДОРХОЙЛОХ, КОДЛОХ УЯЛДУУЛСАН СИСТЕМД
ҮНДЭСЛЭСЭН ГАДААД ХУДАЛДААНЫ БАРААНЫ АНГИЛЛЫН
ЖАГСААЛТЫН ЗАРИМ БАРААНЫ ХЭМЖИХ НЭГЖИД ОРУУЛАХ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

Д/д	Мөр	Үнд. код	Барааны бичиглэл	Хэмжих нэгж
39-Р БҮЛЭГ				
1.	Үндэсний код 3925.20.20-д харгалзах хэмжих нэгжид дараах өөрчлөлтийг оруулах:			
1.1	3925.20		- Хаалга, цонх болон тэдгээрийн хүрээ, хаалганы босго:	
1.2	3925.20	10	--- Хаалга	м ²
1.3	3925.20	20	--- Цонх	м ²
1.4	3925.20	30	--- Хаалга, цонхны хүрээ, хаалганы босго	м ²
70-Р БҮЛЭГ				
2.	Үндэсний код 7008.00.00-д харгалзах хэмжих нэгжид дараах өөрчлөлтийг оруулах:			
2.1	7008.00	00	Олон давхар ханатай тусгаарлагч шил	м ²
76-Р БҮЛЭГ				
3.	Үндэсний код 7610.00.00-д харгалзах хэмжих нэгжид дараах өөрчлөлтийг оруулах:			
3.1	7610.10	00	- Хаалга, цонх, тэдгээрийн хүрээ, хаалганы босго	м ²

*Гаалийн ерөнхий газрын даргын
2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
А/24 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт*

ҮНДЭСНИЙ КОДЫН ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

Өмнө мөрдөж байсан үндэсний код	2026.04.01-ний өдрөөс мөрдөх үндэсний код
0406.10.90	0406.10.30
1515.90.00	1515.90.10 1515.90.20 1515.90.90

ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар А/141

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ, ТАНИХ ТЭМДЭГ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/122 дугаар тушаалд “Газар зүйн заалтыг бүртгэгдсэнийг илэрхийлэх таних тэмдэг, хэрэглэх журам”-ыг хорин гуравдугаар хавсралтаар нэмж, нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/122 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг гаргах, шүүлт хийх, тэдгээрийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах журам”-д дор дурдсан агуулга бүхий дараах хэсэг, зүйл, бүлэг, заалтыг тус тус нэмсүгэй.

3.1.“5.20.Шүүлт хийх явцад шинжээч нь мэдүүлэгтэй холбоотой аливаа мэдээллийг тодруулах, эсхүл Монгол Улс 2010 оны 06 дугаар сарын 10-ны өдөр нэгдэн орсон Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээгээр хориглоогүй аливаа нэмэлт материалыг шаардаж болно.”

3.2.“10.3.Бүртгэлийн мэргэжилтэн мэдэгдлийг хүлээн авч, улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, энэ тухай Журмын хавсралт Маягт БТ-21-ийн дагуу мэдэгдэл үйлдэж, баталгаажуулан, эзэмшигчид цаасаар эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.”

3.3.“13.2. Монгол Улсад бүртгүүлэхээр гаргаж байгаа Гадаад улсын газар зүйн заалтын мэдүүлгийг Оюуны өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.

13.3.Мэдүүлэг нь Журмын хавсралт “Маягт ГЗ3-1”-ээр гаргасан өргөдөл болон хуулийн 21.6-д заасан зүйлээс бүрдэнэ.

13.4.Хуулийн 21.6.5-д заасан тодорхойлолтыг Журмын хавсралт “Маягт ГЗЗ-2”-ын дагуу бичнэ.

13.5.Мэдүүлгийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргаж байгаа бол Журмын хавсралт хавсралт “Маягт ГЗЗ-11”-ын дагуу олгосон итгэмжлэлийг хавсаргана.

13.6. Гадаад улсын газар зүйн заалтыг мэдүүлж байгаа бол Хуулийн 21.6.3-т заасан баримт болон Хуулийн 21.6.5-т заасан тодорхойлолтыг орчуулгын хамт хавсаргана.

13.7.Журмын 13.6-д заасан орчуулгыг мэдүүлэг гаргахдаа, эсхүл мэдүүлэг гаргасан өдрөөс хойш өдрөөс хойш 2 сарын дотор ирүүлнэ.”

3.4.“АРВАН ДӨРӨВ. ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН МЭДҮҮЛГИЙН БҮРДЛИЙГ ХЯНАХ

14.1.Бүртгэлийн мэргэжилтэн нь Аж үйлдвэрийн өмчийн цахим мэдээллийн санд холбогдох мэдээллийг оруулж, Журмын хавсралт “Маягт ГЗЗ-7” -ын дагуу мэдүүлэг хүлээн авсан тухай мэдэгдлийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр мэдүүлэг гаргагчид илгээнэ.

14.2.Бүртгэлийн мэргэжилтэн нь тухайн газар зүйн заалтын мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш хуулийн 23.1-д заасны дагуу ажлын 10 хоногийн дотор хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан бүрдлийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг шалгана.

14.3.Бүртгэлийн мэргэжилтэн мэдүүлгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл цахим мэдээллийн санд “бүрдэл хангагдсан” төлөвийг сонгож, цахим мэдээллийн сангаар дамжуулан нийтэд мэдээлснээр мэдүүлэг гаргачид мэдэгдсэнд тооцно.

14.4.Бүртгэлийн мэргэжилтэн газар зүйн заалтын мэдүүлгийн бүрдэл хангаагүй гэж үзвэл журмын хавсралт “Маягт ГЗЗ-3” маягтын дагуу мэдэгдлийг үйлдэж, хуулийн 23.3-т заасны дагуу мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ. Тухайн мэдэгдлийг мэдүүлэг гаргагчийн шуудангийн эсхүл цахим шуудангийн хаягаар илгээснээр, эсхүл цаасаар гардуулж өгснөөр мэдүүлэг гаргагчид мэдэгдсэнд тооцох ба мэдэгдсэн өдрөөс зохих засвар хийж ирүүлэх хугацаа тоологдож эхэлнэ.

14.5.Мэдүүлэг гаргагч нь хуулийн 23.4-т заасны дагуу ажлын 10 хоногийн дотор шаардлагатай засварыг хийж, бүртгэлийн мэргэжилтэнд хүргүүлнэ. Шуудангаар явуулах тохиолдолд заасан хугацаанд шуудангийн газарт өгнө.

14.6.Хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасны дагуу бүртгэлийн мэргэжилтэн нь уг засварыг хангасан гэж үзвэл мэдүүлгийн анхдагч огноог мэдүүлгийг анх хүлээн авсан өдрөөр тогтоож, журмын 14.3-т заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

14.7.Мэдүүлэг гаргагч журмын 14.5-д заасан хугацаанд засварыг хийж ирүүлээгүй тохиолдолд бүртгэлийн мэргэжилтэн мэдүүлэг

гаргагчийг мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдэгдлийг журмын хавсралт “Маягт ГЗЗ-4”-ийн дагуу үйлдэж, хуулийн 23.8-д заасны дагуу мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

14.8.Журмын 14.5-д заасны дагуу зохих засварыг шуудангаар илгээсэн боловч хэрэв саатсан бол шуудангийн байгууллагаас өгсөн баримтыг үндэслэн бүртгэлийн мэргэжилтэн уг засварыг журмын 14.5-т заасан хугацаанд хийж ирүүлсэн гэж үзэж, журмын 14.3-т заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.5.“АРВАН ТАВ. ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН МЭДҮҮЛЭГТ ШҮҮЛТ ХИЙХ

15.1.Шинжээч мэдүүлсэн газар зүйн заалт нь хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхэд хуулийн 24.1-д заасны дагуу шүүлт хийж, дүгнэлт гаргана.

15.2.Бүртгүүлэхээр мэдүүлсэн заалт нь Хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэхийг тогтоохдоо шинжээч мэдүүлэгт хавсаргасан тодорхойлолтыг судалж үзэн, шаардлагатай тохиолдолд мэдүүлэг гаргагчийг нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлэхийг шаардаж болно.

15.3.Шинжээч газар зүйн заалтын мэдүүлэгт шүүлт хийхдээ холбогдох чиглэлээр мэргэшсэн хөндлөнгийн мэргэжилтнээр дүгнэлт гаргуулж болно.

15.4.Шинжээч дүгнэлт гаргахдаа журмын 15.3-т заасан дүгнэлтийг үндэслэл болгож болно.

15.5.Шинжээч хуулийн 24.3-т заасан дүгнэлтийг журмын хавсралт “Маягт ГЗЗ-05”-ын дагуу, 24.4-т заасан дүгнэлт ба шийдвэрийг “Маягт ГЗЗ-8”-ын дагуу, 24.7-д заасан шийдвэрийг “Маягт ГЗЗ-6”-ын дагуу тус тус гаргана.”

3.6.“АРВАН ЗУРГАА. ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, МЭДЭЭЛЭХ

16.1.Газар зүйн заалтын улсын бүртгэлд газар зүйн заалт хэрэглэгчийн хүсэлтээр хуулийн 25.6-д заасан үндэслэлээр өөрчлөлт оруулна.

16.2.Энэ журмын 16.1-д заасан хүсэлтийг “Маягт ГЗЗ-09”-ын дагуу гаргана.

16.3.Хүсэлтийг бүртгэлийн мэргэжилтэн хүлээн авч, улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, энэ тухай мэдэгдлийг “Маягт ГЗЗ-10”-ын дагуу үйлдэж, хүсэлт гаргагчид хүргүүлэх ба хуулийн 25.9-д заасны дагуу нийтэд мэдээлнэ.

3.7.Журмын 5 дугаар зүйлийн 5.4 дахь хэсгийн “5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл” гэсний дараа “эсхүл сонирхогч этгээдээс гаргасан эсэргүүцлийг үндэслэн” гэж нэмсүгэй.

4.Журмын 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсгийн “мэдүүлгийг зохих

төлөвт шилжүүлж, 7 дугаар зүйлийн 7.2-д заасан мэдэгдлийг Журмын хавсралт Маягт БТ-04-ийн дагуу үйлдэж, мэдүүлэг гаргагчид цаасаар, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.” гэснийг “цахим системд “бүрдэл хангасан” төлөвийг сонгож, цахим сангаар нийтэд мэдээлснээр мэдүүлэг гаргачид мэдэгдсэнд тооцно.” гэж, 13 дугаар зүйлийн **“ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ, ШҮҮЛТ ХИЙХ, ТЭДГЭЭРИЙГ БҮРТГЭХ, УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ТЭДГЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ”** гэснийг **“ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ”** гэж, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийн “13.1.Газар зүйн заалтын мэдүүлэг гаргах, шүүлт хийх, тэдгээрийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулахад Журмын холбогдох заалтыг баримтална.” гэснийг “13.1.Мэдүүлгийг хуулийн 21.1-д заасан этгээд өөрөө, эсхүл Оюуны өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

5.Журмын 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсгийн “3D зургийг хавсаргах бөгөөд үүний” гэснийг “3D зургийн” гэж, 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “нийтэд мэдээлнэ.” гэснийг “нийтэд мэдэлснээр мэдүүлэг гаргагчид мэдэгдсэнд тооцно.” гэж, 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсгийн “3.3, 3.4-т тус тус” гэснийг “3.3-т” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “хуулийн 8 дугаар зүйлийн 8.10-т заасан хугацаанд Журмын хавсралт Маягт БТ-07-ын дагуу сонирхогч этгээд эсэргүүцэл гаргаж, нотлох баримт хавсаргана.” гэснийг “сонирхогч этгээд Журмын хавсралт Маягт БТ-07-ын дагуу үйлдсэн эсэргүүцлийг нотлох баримтын хамт эсхүл хуулийн 8.11-т заасан хүсэлтийг хуулийн 8 дугаар зүйлийн 8.10-т заасан хугацааны дотор гаргана.” гэж, “3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11, 3.12 дахь хэсэг”-ийн дугаарыг “3.4, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11” гэж, “4.3, 4.4, 4.5 дахь хэсэг”-ийн дугаарыг “4.2, 4.3, 4.4” гэж тус тус өөрчилсүгэй.

6. Журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Г.Гантулга), Аж үйлдвэрийн өмчийн газар (С.Урангэрэл)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Г.ЭЛБЭГСАЙХАН

*Оюуны өмчийн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний
өдрийн А/141 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫГ БҮРТГЭГДСЭНИЙГ ИЛЭРХИЙЛЭХ ТАНИХ ТЭМДЭГ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь газар зүйн заалт бүртгэгдсэнийг илэрхийлэх таних тэмдгийг ашиглах эрх олгох, ашиглах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Монгол Улсад газар зүйн заалтаар бүртгүүлсэн гадаад орны гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүнд энэ журам хамаарахгүй.

Хоёр.Газар зүйн заалтын таних тэмдгийн техникийн тодорхойлолт

2.1.Газар зүйн заалтыг бүртгэгдсэнийг илэрхийлэх таних тэмдэг нь монгол орны говь, хангай хосолсон байгалийн өвөрмөц төрхийг монголын уламжлалт нүүдлийн өв соёлыг илэрхийлсэн тэмээн жингийн цувааны хамт монгол гэрийн хэлбэрт оруулан зохиомжилсон дүрслэлтэй. Доод талд нь “Монгол Улсын хамгаалагдсан газар зүйн заалт”, англи хувилбар нь “Protected Geographical indication of Mongolia” гэсэн бичвэртэй байна.

2.2.Газар зүйн заалтын таних тэмдгийн өнгө нь зөөлөн дулаан өнгөөр илэрхийлсэн ба цэнхэр, номин, шар, улбар шар өнгө орсон. Цэнхэр, номин өнгө нь мөнх хөх тэнгэр болон алтайн өндөр уулсыг илэрхийлсэн бол шар, улбар шар өнгө нь өргөн уудам говь, цөлийг илэрхийлсэн.



**МОНГОЛ УЛСАД
ХАМГААЛАГДСАН ГАЗАР
ЗҮЙН ЗААЛТ**



**PROTECTED GEOGRAPHICAL
INDICATION OF MONGOLIA**

2.3.Бүртгэгдсэн газар зүйн заалттай бүтээгдэхүүний шошго, сав баглаа, сурталчилгааны болон бусад зөвшөөрөгдсөн материал дээр таних тэмдгийг монгол, англи хэл дээр хэвлэж, эсхүл электрон хэлбэрээр ашиглана. Таних тэмдэг нь өнгөт, эсхүл хар, цагаан хувилбараар байж болно.

Гурав.Таних тэмдэг ашиглах, эрх олгох

3.1.Таних тэмдгийг өмчлөх эрх нь Оюуны өмчийн газарт хадгалагдах ба гэрчлэх тэмдгээр бүртгэгдсэн байна.

3.2.Газар зүйн заалт бүртгэгдэсний дараа Оюуны өмчийн газар таних тэмдгийг ашиглах эрхийг түүний тодорхойлолт, загварын хамт газар зүйн заалт хэрэглэгчид олгоно.

3.3.Таних тэмдгийг газар зүйн заалт хэрэглэгч нэгдэл, холбоо, байгууллага болон тэдгээрийн газар зүйн заалтын бүртгэлд дурдагдсан гишүүн үйлдвэрлэгчид ашиглах бөгөөд газар зүйн заалтын бүтээгдэхүүний тодорхойлолтод заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

3.4.Нэгдэл, холбоо, байгууллага нь тэдгээрийн гишүүнчлэлд өөрчлөлт орох бүрд Оюуны өмчийн газарт мэдэгдэж, бүртгэлд өөрчлөлт оруулах үүрэгтэй.

3.5.Газар зүйн заалтын хэрэглэгчид таних тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгэгдсэн газар зүйн заалттай бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнд ашиглах, дуурайлган үйлдэх, энэ журмын 2 дугаар зүйлд заасан загвар, техникийн тодорхойлолтыг өөрчилж ашиглахгүй.

Дөрөв.Таних тэмдгийн ашиглалтад тавих хяналт

4.1.Таних тэмдгийн ашиглалтад тавих хяналтыг Оюуны өмчийн газар дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ.

4.1.1.Төлөвлөгөөт хяналт шалгалт

4.1.2. Гомдол, хүсэлтийн дагуу.

4.2. Таних тэмдгийг энэ журамд зааснаас өөр хэлбэрээр ашиглах, эрхгүй этгээд ашиглахыг хориглоно.

Тав.Таних тэмдэг ашиглах эрх дуусгавар болох

5.1.Таних тэмдэг хэрэглэх эрх Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 28.1-д заасны дагуу газар зүйн заалт хэрэглэгчийн эрх дуусгавар болсноор дуусгавар болно.

5.2. Оюуны өмчийн газар энэ журмын 5.1-д заасны дагуу таних тэмдэг хэрэглэх эрх дуусгавар болсон тухай Оюуны өмчийн тухай хуулийн 3.1.4-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.